4-3

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2010 оны 01 сарын 14 өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

**БАГШ НАРЫН БАЯРТ ЗОРИУЛСАН СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ НЬ**:

**Нэг**. Багш нарын баярт зориулсан сагсан бөмбөг, ширээний теннисний тэмцээнүүдийг 2010 оны 01 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд Нийслэлийн Боловсролын газартай хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

**Хоёр**. Дээрх тэмцээнүүдийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

**Гурав**. Дээрх тэмцээнүүдийг зохион байгуулахад шаардагдах 564.000 /таван зуун жаран дөрвөн мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын биеийн тамир, чийрэгжүүлэлтийн арга хэмжээний зардлаас гаргахыг ня-бо /Ж.Цэдэнсодном/-д зөвшөөрсүгэй.

**Дөрөв**. Дээрх тэмцээнүүдийн урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн /Г.Бямбасайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ГАНБОЛД

ТТБ3279 ⚓ 9077446

injunction-2010 050003

НБТСГ-ын дарга 2010 оны 01 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## БАГШ НАРЫН БАЯРТ ЗОРИУЛСАН САГСАН БӨМБӨГ, ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

| № | Зардлын нэр | Нийт дүн |
|---|---|---|
| 1 | Тамирчдын шагнал:<br>1-р байр 16 хүн 10000 төг = 160000 төг<br>2-р байр 16 хүн 8000 төг = 128000 төг<br>3-р байр 16 хүн 6000 төг = 96000 төг | 384.000 |
| 2 | Шүүгчдийн ажлын хөлс:<br>/6 хүн х 2 өдөр х 15000 төг/ | 180.000 |
| | **ДҮН:** | **564.000 төг** |